



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС - PMI

2026.II
улирал

2026 оны 7 дугаар сар

МОНГОЛБАНК

Энэхүү үзүүлэлтийг олон улсад нийтлэг ашиглагддаг аргачлалын дагуу бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчид болон олон нийтийн хэрэгцээнд зориулж улирлын давтамжтай тогтмол гаргаж байна.

1. Худалдан авалтын менежерийн индекс (PMI)

Ерөнхий индекс: Монгол Улсын худалдан авалтын менежерийн ерөнхий индексийн утга 2026 оны II улиралд агших мужид **44.5** утгатай гарч сүүлийн 6 улирал дараалан агших мужид хэвээр хадгалагдлаа. PMI индекс өмнөх улирлаас 5.1 нэгжээр өсөхөд үйлдвэрлэл, шинэ захиалгын өсөлт голлох нөлөөг үзүүллээ (Зураг 1-2).


Нийлмэл индекс: Нийлмэл индексүүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа уртассан буюу 1 улирлын дараа эргэн агших мужид шилжсэн бол бусад үзүүлэлтүүд агших мужид хэвээр гарлаа. Ийнхүү үйлдвэрлэл болон шинэ захиалгын индексийн утга тус бүр сүүлийн 6, бараа материалын нөөцийн индекс 4, ажил эрхлэлт 3 улирал дараалан агших мужид тус тус гараад байна. Өмнөх улирлын үр дүнтэй харьцуулахад нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индекс бага зэрэг буурсан бол бусад үзүүлэлтүүд өсжээ (Зураг 2).

Салбарын индекс: Тайлант улиралд үйлчилгээний салбар өмнөх улирлаас 0.3 нэгжээр агшиж 41.9 утгатай гарсан бол бусад салбарууд агших мужид хэвээр боловч өмнөх улирлаас нэлээд өссөн байна. Тухайлбал аж үйлдвэрийн салбарын хувьд өмнөх улирлаас 9.0 нэгжээр өсөж 47.2, барилгын салбарын хувьд өмнөх улирлаас 8.4 нэгжээр өсөж 42.0, дотоод худалдааны салбар өмнөх улирлаас 8.1 нэгжээр өсөж 44.3 утгатай гарсан байна. Ийнхүү индексийн утга дийлэнх салбаруудын хувьд өссөн боловч барилгын салбар 22, дотоод худалдаа 7, үйлчилгээ 6, аж үйлдвэрийн салбар 2 улирал дараалан агших мужид хадгалагдав (Зураг 3).


Зураг 1. Ерөнхий индекс



Зураг 2. Нийлмэл индекс



Зураг 3. Ерөнхий индекс, салбараар




Зураг 4. Эдийн засгийн өсөлт болон үйлдвэрлэлийн индекс

Үйлдвэрлэлийн индекс нь эдийн засгийн өсөлтийн хандлагыг урьдчилан илэрхийлэх боломжтой үзүүлэлт юм. 2026 оны II улирлын үйлдвэрлэлийн индексийн утга 45.7 утгатай гарсан нь тайлант улиралд эдийн засаг агших төлөвтэйг илэрхийлж байгаа хэдий ч өмнөх улирлаас 12 нэгж хувиар өссөн нь эерэг үзүүлэлт боллоо (Зураг 4).

Бизнесийн үйл ажиллагааны төлөв: Барилгын салбарын бизнесийн үйл ажиллагааны төлөвийн индекс 5 улирлын дараа, аж үйлдвэрийн салбарын индекс 3 улирлын дараа эргэн тэлэлтийн мужид шилжсэнээр тус салбарууд ирэх улиралд өсөх хүлээлттэй байна. Харин үйлчилгээний салбарын бизнесийн үйл ажиллагааны төлөвийн индекс агших мужид шилжсэнээр тус салбар ирэх улиралд буурах хүлээлттэй байна. Дотоод худалдааны салбарын хувьд индексийн утга агших мужид хэвээр гарснаар 2026 оны III улиралд тус салбаруудын бизнесийн үйл ажиллагаа сайжрахгүй, өөдрөг бус байна (Зураг 5).



Зураг 5. Бизнесийн үйл ажиллагааны төлөвийн индекс, салбараар




2. Салбарын ерөнхий ба нэмэлт үзүүлэлтүүд

Аж үйлдвэр: Салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд 2026 оны II улиралд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт бага зэрэг буурсан боловч тэлэлтийн мужид хэвээр гарлаа. Харин бусад үзүүлэлтүүд өмнөх улирлаас өссөн боловч агших мужид хэвээр гарчээ. Өмнөх улирлын утгатай харьцуулахад нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 5.7 нэгжээр буурсан бол үйлдвэрлэл 18.5, шинэ захиалга 12.4, бараа материалын нөөц 5.1, ажил эрхлэлт 4.8 нэгжээр тус тус өсжээ (Зураг 6).

Аж үйлдвэрийн салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд бэлэн бүтээгдэхүүн, худалдан авалтын тоо хэмжээний үзүүлэлтээс бусад үзүүлэлтүүд тэлэлтийн мужид гарчээ. Өмнөх улиралтай харьцуулахад 0.4 нэгжээр бага зэрэг буурсан байна. Харин худалдан авалтын тоо хэмжээ 15.1, бизнесийн үйл ажиллагааны төлөв 13.4, дуусаагүй үйлдвэрлэл 10.4, бэлэн бүтээгдэхүүн 8.8, түүхий эд, материалын үнийн үзүүлэлт 3.0 нэгжээр тус тус өссөн байна /Хүснэгт 1/.

Барилга: Тайлант улиралд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт агших мужаас тэлэлтийн агших мужид шилжиж хүргэлтийн хугацаа богиноссон бол бусад үзүүлэлтүүд өссөн боловч агших мужид хэвээр хадгалагдсан байна. Харин өмнөх улирлын утгатай харьцуулбал үйлдвэрлэл 13.2 нэгж, шинэ захиалга 11.7, бараа материалын нөөцийн үзүүлэлт 6.8, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт 6.6 нэгжээр өссөн бол ажил эрхлэлт 0.2 нэгжээр буурчээ (Зураг 7).


Зураг 6. Аж үйлдвэрийн салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2025 III	2025 IV	2026 I	2026 II
Дуусаагүй үйлдвэрлэл	51.1↓	58.9↑	41.5↓	51.8↑
Бэлэн бүтээгдэхүүн	40.6↓	62.0↑	39.2↓	48.0↑
Бүтээгдэхүүний үнэ	61.6↓	71.2↑	76.5↑	76.0↓
Худалдан авалтын тоо хэмжээ	44.9↓	54.5↑	30.3↓	45.4↑
Түүхий эд, материалын үнэ	79.1↓	88.0↑	88.7↑	91.7↑
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	41.8↓	49.8↑	38.9↓	52.2↑

Зураг 7. Барилгын салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Барилгын салбарын нэмэлт үзүүлэлтүүдийг авч үзвэл түүхий эд материалын үнэ, бизнесийн үйл ажиллагааны төлөвийн үзүүлэлтээс бусад үзүүлэлтүүд агших мужид гарчээ. Өмнөх улирлаас бизнесийн үйл ажиллагааны төлөв өмнөх улирлаас 15.7, худалдан авалтын тоо хэмжээ 10.2, орон сууцны зах зээлийн идэвхжил 9.5, барилга угсралтын үйл ажиллагаа 6.7, туслан гүйцэтгэгч ашиглалт 2.2 нэгжээр тус тус өслөө. Харин түүхий эд материалын үнэ 1.5 нэгж, борлуулалтын үйл ажиллагаа 1.1 нэгжээр буурсан /Хүснэгт 2/.


Дотоод худалдаа: 2026 оны II улиралд салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд үйлдвэрлэл (борлуулалтын орлого)-ийн үзүүлэлт өмнөх улирлаас 22.1 нэгжээр эрс нэмэгдэж тэлэлтийн мужид шилжиж сайжирсан бол бараа материалын нөөц 3.4 нэгжээр буурч агших мужид шилжлээ. Бусад үзүүлэлтүүд агших мужид хэвээр гарлаа. Өмнөх улирлын утгатай харьцуулахад шинэ захиалга 8.2, ажил эрхлэлт 5.2 нэгжээр тус тус өссөн бол, харин нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 3.2 нэгжээр буурсан байна (Зураг 8).

Нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд хүлээгдэж буй борлуулалтаас бусад 2 үзүүлэлт тэлэлтийн мужид гарчээ. Өмнөх улиралтай харьцуулахад түүхий эд материалын үнэ 2.3 нэгжээр өссөн бол худалдан авсан барааны хэмжээ 0.6 нэгжээр буурчээ. Харин хүлээгдэж буй борлуулалт өмнөх улирлаас 2.5 нэгжээр өссөн хэдий ч сүүлийн 16 улирал дараалан агших мужид гарсан нь салбарын хүлээлт сайжрахгүй байгааг илтгэж байна /Хүснэгт 3/.

Хүснэгт 2. Барилгын салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2025 III	2025 IV	2026 I	2026 II
Худалдан авалтын тоо хэмжээ	46.2↑	42.0↓	36.7↓	46.9↑
Түүхий эд, материалын үнэ	84.8↓	89.9↑	93.2↑	91.8↓
Орон сууцны зах зээлийн идэвхжил	39.5↑	37.5↓	22.7↓	32.2↑
Борлуулалтын үйл ажиллагаа	31.4↓	30.5↓	34.2↑	33.1↓
Барилга, угсралтын үйл ажиллагаа	37.5↓	38.6↑	42.8↑	49.5↑
Туслан гүйцэтгэгч ашиглалт	45.3↑	39.2↓	41.5↑	43.7↑
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	39.5↓	44.5↑	39.1↓	54.8↑

Зураг 8. Дотоод худалдааны салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр




Хүснэгт 3. Дотоод худалдааны салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2025 III	2025 IV	2026 I	2026 II
Түүхий эд, материалын үнэ	80.0↑	71.0↓	85.8↑	88.1↑
Худалдан авсан барааны хэмжээ	81.1↑	71.3↓	90.1↑	89.5↓
Хүлээгдэж буй борлуулалт	21.7	18.8↓	14.7↓	17.2↑

Үйлчилгээ: Салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд шинэ захиалга, үйлдвэрлэл (бизнесийн идэвхжил), ажил эрхлэлтийн үзүүлэлт тус тус сүүлийн 6 улирал, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт сүүлийн 3 улирал дараалан агших мужид гарлаа. Өмнөх улирлын утгатай харьцуулахад үйлдвэрлэл 2.0 нэгж, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 0.2, шинэ захиалга 0.1 нэгжээр тус тус өссөн бол ажил эрхлэлт 4.2 нэгжээр буурчээ (Зураг 9).

Үйлчилгээний салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд бизнесийн үйл ажиллагааны төлөвийн үзүүлэлт агших мужид шилжиж буурсан бол бусад үзүүлэлтүүдийн хувьд өмнөх улирлаас бага зэрэг буурсан боловч тэлэлтийн мужид хэвээр гарлаа. Бизнесийн үйл ажиллагааны төлөвийн үзүүлэлт өмнөх улирлаас 8.0 нэгж, дуусаагүй ажил үйлчилгээний үзүүлэлт 5.5 нэгж, үйлчилгээний үнийн үзүүлэлт өмнөх 2.3 нэгж, түүхий эд, материалын үнийн үзүүлэлт 0.7 нэгжээр нэгжээр тус тус буурсан байна /Хүснэгт 4/.

Зураг 9. Үйлчилгээний салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр




Хүснэгт 4. Үйлчилгээний салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2025 III	2025 IV	2026 I	2026 II
Түүхий эд, материалын үнэ	78.5↓	82.8↑	92.7↑	92.0↓
Үйлчилгээний үнэ	68.2↓	66.2↓	72.2↑	70.0↓
Дуусаагүй ажил үйлчилгээ	63.6↑	64.3↑	60.5↓	55.0↓
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	42.1↓	41.3↓	50.9↑	42.9↓

3. ААН-ийн хэмжээгээр PMI индекс

Аж ахуйн нэгжүүдийг жилийн борлуулалтын орлогын хэмжээгээр жижиг (1.0 тэрбум хүртэл ₮), дунд (1.0-2.5 тэрбум ₮), том (2.5-с дээш тэрбум ₮) гэж ангилан тайлант улирлын PMI индексийн утгыг тооцвол том ААН-үүдийн индексийн утга 6, дунд ААН-үүд 7, жижиг ААН-үүд 22 улирал дараалан агших мужид гараад байна. Индексийн утгыг өмнөх улиралтай харьцуулахад том ААН-үүд 5.4, дунд ААН-үүд 1.4 нэгжээр тус тус өсөж, харгалзан 45.3, 35.7 байв. Харин жижиг ААН-үүдийн индексийн утга 1.9 нэгжээр буурч 34.9 гарчээ (Зураг 10).

Зураг 10. PMI индекс, аж ахуйн нэгжийн хэмжээгээр




Жижиг: ААН-үүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа богиноссоноор үзүүлэлт өсөж, тэлэлтийн мужид хэвээр хадгалагдлаа. Харин бусад бүх үзүүлэлт агших мужид хэвээр гарсан байна. Өмнөх улиралтай харьцуулахад шинэ захиалга 7.7, бараа материалын нөөц 6.9 нэгжээр буурсан бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 3.8, ажил эрхлэлт 1.6, үйлдвэрлэл 0.8 нэгжээр тус тус өслөө (Зураг 11).


Дунд: ААН-үүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт тэлэлтийн мужид шилжсэн бол бусад бүх үзүүлэлт агших мужид гарлаа. Өмнөх улиралтай харьцуулахад бараа материалын нөөц 4.4 нэгж, үйлдвэрлэл 3.6 нэгжээр буурсан бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 5.8, ажил эрхлэлт 4.9, шинэ захиалга 3.2 нэгжээр тус тус өсжээ (Зураг 12).

Том: ААН-үүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт агших мужид шилжсэнээр нийт үзүүлэлтүүд агших мужид гарлаа. Өмнөх улирлын утгатай харьцуулахад үйлдвэрлэл 12.9, шинэ захиалга 7.2, бараа материалын нөөц 3.9, ажил эрхлэлт 0.3 нэгжээр тус тус өссөн бол, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 3.0 нэгжээр буурчээ (Зураг 13).


Зураг 11. Жижиг ААН-үүд, үзүүлэлтүүдээр



Зураг 12. Дунд ААН-үүд үзүүлэлтүүдээр



Зураг 13. Том ААН-үүд үзүүлэлтүүдээр



ААН-ийн ерөнхий мэдээлэл

Тус судалгаанд аж үйлдвэр, барилга, дотоод худалдаа (бөөний болон жижиглэн) болон үйлчилгээний салбаруудаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй, эх олонлогийг төлөөлөхүйц аж ахуйн нэгжүүдийг хамруулсан бөгөөд салбар бүрийн аж ахуйн нэгжүүдийг жилийн борлуулалтын орлогоор **жижиг** (1.0 тэрбум хүртэл ₮), **дунд** (1.0-2.5 тэрбум ₮), **том** (2.5-с дээш тэрбум ₮) гэж ангилсан. Ингэхдээ тухайн ангилалд хамаарах бүх аж ахуйн нэгжүүдээс жилийн борлуулалтын орлогоор тэргүүлэх аж ахуйн нэгжүүдийг түүвэрт сонголоо.

Түүвэр судалгааны асуулгыг **2026 оны 6-р сард** зохион байгуулж, **нийт 401** аж ахуйн нэгжүүд судалгаанд хамрагдсан бөгөөд **аж үйлдвэрийн салбарын 130, барилгын салбарын 63, дотоод худалдааны салбарын 78, үйлчилгээний салбарын 130** аж ахуйн нэгжүүд байв. Борлуулалтын орлогын хэмжээгээр авч үзвэл жижиг ангилалд хамаарах 138 (34%), дунд 79 (20%), том 184 (46%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо /Хүснэгт 5/.

Хүснэгт 5. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, жилийн борлуулалтын орлогын бүлгээр¹

Ерөнхий салбар	Салбар	ААН-ийн тоо 2026.1*	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр (130)	Уул уурхай, олборлолт	1,256	1	1	11	13	3%
	Боловсруулах үйлдвэрлэл	7,910	39	21	42	102	25%
	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	4,957	6	1	2	9	2%
	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	309	1	-	4	5	1%
	Усан хангамж	259	-	-	1	1	0%
Барилга	Барилга	9,139	12	20	31	63	16%
Дотоод худалдаа	Бөөний болон жижиглэн худалдаа	45,818	32	16	30	78	19%
Үйлчилгээ (130)	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	4,887	4	2	8	14	3%
	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	3,458	3	-	7	10	2%
	Мэдээлэл, холбоо	3,369	2	-	8	10	2%
	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2,045	1	4	7	12	3%
	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1,262	-	-	2	2	0%
	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн ү.а	7,537	-	1	1	2	0%
	Боловсрол	3,977	3	-	2	5	1%
	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2,972	5	3	4	12	3%
	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	9,062	29	10	24	63	16%
Нийт		108,217	138	79	184	401	100%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тухайн байгууллагын ажиллагсдын тооны бүлгээр ангилан авч үзвэл 49 хүртэл ажилтантай 290 (72%), 50-199 хүртэл ажилтантай 75 (19%), 200 ба түүнээс дээш ажилтантай 36 (9%) аж ахуйн нэгж судалгаанд хамрагджээ /Хүснэгт 6/.

¹ 2026 оны I улирлын байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн тоо

Хүснэгт 6. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, ажилтны тооны бүлгээр

Ерөнхий салбар	Ажилтны тоо	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр	1-49 хүртэл	47	20	26	93	23%
	50-200 хүртэл		3	18	21	5%
	200-с дээш			16	16	4%
Барилга	1-9 хүртэл	11	18	19	48	12%
	50-200 хүртэл	1	2	8	11	3%
	200-с дээш			4	4	1%
Дотоод худалдаа	1-49 хүртэл	32	15	20	67	17%
	50-200 хүртэл		1	6	7	2%
	200-с дээш			4	4	1%
Үйлчилгээ	1-49 хүртэл	45	18	19	82	20%
	50-200 хүртэл	2	2	32	36	9%
	200-с дээш			12	12	3%
Нийт	1-49 хүртэл	135	71	84	290	72%
	50-200 хүртэл	3	8	64	75	19%
	200-с дээш	-		36	36	9%
Нийт		138	79	184	401	100%

Худалдан авалтын менежерийн индексийн тухай

Худалдан авалтын менежерийн индекс (PMI) нь бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид болон аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудын хувьд эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг харах, үйл ажиллагаагаа удирдах, төлөвлөх, урьдчилан таамаглах, шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой үзүүлэлт болдог. PMI нь тооцоход хялбар энгийн аргачлал дээр үндэслэгдэж, албан ёсны статистик тоон мэдээлэл гарахаас өмнө эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг тодорхойлохын зэрэгцээ бусад орнуудтай харьцуулалт хийх боломж олгодгоороо давуу талтай.

Олон улсын туршлагаас харахад уг индексийг тооцохдоо эдийн засгийн голлох салбаруудын нөлөө бүхий 400 орчим аж ахуйн нэгжүүдийг сонгон түүвэрлэлтэд хамруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, шинэ захиалга, ажил эрхлэлт, бараа материалын нөөц, хүргэлтийн хугацаа болон бусад үзүүлэлтийн талаарх мэдээллийг судалж, эдгээр үзүүлэлт бүрээр индексийн утгыг тооцон, индексийн өөрчлөлтийг харгалзан дүгнэлт өгдөг.

“Худалдан авалтын менежерийн индекс (Purchasing manager index-PMI)” нь эдийн засгийн ерөнхий хандлагыг харуулсан чиглэлийн индекс юм.

Аргачлал: Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс үзүүлэлт тус бүрийн хувьд өмнөх улирлаас хэрхэн өөрчлөгдсөн талаар чанарын асуулт асууж, хариултуудыг нэгтгэх замаар тоон буюу индексийн утгад шилжүүлнэ. Индексийг үзүүлэлт тус бүрээр тооцон гаргаж салбаруудын индекс, нийлмэл индекс, нийт эдийн засгийн индексийг тооцоолоход ашиглана.

$$\text{PMI (тухайн үзүүлэлтийн тархалтын индекс)} = (K1 * 1) + (K2 * 0.5) + (K3 * 0)$$

$k1$ = Өссөн гэсэн хариултын хувь

$k2$ = Хэвэндээ гэсэн хариултын хувь

$k3$ = Буурсан гэсэн хариултын хувь

Уг индексийн тооцоолсон утгыг **тархалтын индекс** гэж нэрлэх бөгөөд PMI=50 бол бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүйг, PMI>50 бол бизнесийн үйл ажиллагааны тэлэлтийг, PMI<50 бол агшилтыг тус тус илэрхийлдэг. Энэхүү утга 50-аас холдох тусам тэлэлт эсвэл агшилт ихэснэ. Тодруулбал, PMI-ийн үзүүлэлт өмнөх улирлын үзүүлэлтээс өндөр байвал эдийн засаг илүү хурдтай тэлж (агшиж) байгааг, харин өмнөх улирлаас доогуур байвал илүү багаар тэлж (агшиж) байна гэсэн утгыг илэрхийлнэ.

Энэхүү судалгаанд PMI-ийг эдийн засгийн голлох салбаруудаар тооцохын зэрэгцээ аж ахуйн нэгжийн жилийн борлуулалтын орлогын хэмжээгээр жижиг (1.0 тэрбум хүртэл ₮), дунд (1.0-2.5 тэрбум ₮), том (2.5-с дээш тэрбум ₮) гэж ангилан, бүлэг тус бүрээр индексийг тооцож гаргасан. Салбарын борлуулалтын орлогын нийт борлуулалтын орлогод эзлэх хувиар нь бүлэг тус бүрийн үзүүлэлтийн тархалтын индексийг жигнэж тухайн үзүүлэлтийн салбар бүр дэх индексийн утгыг тооцлоо. Салбар болон нийт эдийн засгийн PMI-ийг тооцохдоо гол үзүүлэлтүүдийн нийлмэл² индексийг олон улсад нийтлэг ашиглагддаг ач холбогдлын жингээр³ жигнэн тооцсон болно.

² Салбар бүр дэх гол 5 үзүүлэлтүүдийн индексийг ДНБ-д эзлэх хувиар жигнэн тооцсон үзүүлэлт болно.

³ Олон улсын туршлагаар PMI-ийг тооцохдоо шинэ захиалга 30%, үйлдвэрлэлийн хэмжээ 25%, ажил эрхлэлт 20%, нийлүүлэлт хугацаа 15%, бараа материалын нөөц 10%-иар жигнэж тооцдог байна. An introduction to the PMI surveys, IHS Markit.

Аж үйлдвэр

Үзүүлэлт	2024.III	2024.IV	2025.I	2025.II	2025.III	2025.IV	2026.I	2026.II
Аж үйлдвэр	48.9	54.2	45.6	49.7	46.6	51.1	38.2	47.2
Шинэ захиалга	46.5	49.8	39.8	45.3	44.0	52.6	30.6	43.0
Үйлдвэрлэл	54.1	57.1	44.4	49.0	45.0	57.4	29.3	47.9
Ажил эрхлэлт	53.6	57.9	51.4	56.8	51.7	49.7	44.8	49.6
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	36.4	48.4	48.3	44.6	49.0	42.4	58.6	52.8
Бараа материалын нөөц	52.7	61.9	50.5	57.6	44.2	46.7	39.5	44.6
Дуусаагүй үйлдвэрлэл	52.9	52.8	46.0	62.9	51.1	58.9	41.5	51.8
Бэлэн бүтээгдэхүүн	52.7	57.2	54.2	49.0	40.6	62.0	39.2	48.0
Бүтээгдэхүүний үнэ	55.4	69.7	72.2	72.1	61.6	71.2	76.5	76.0
Худалдан авалтын тоо хэмжээ	59.6	56.2	37.8	55.7	44.9	54.5	30.3	45.4
Түүхий эд, материалын үнэ	72.9	85.3	84.9	86.0	79.1	88.0	88.7	91.7
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	59.2	57.0	54.4	52.3	41.8	49.8	38.9	52.2
Жижиг								
Шинэ захиалга	50.9	45.4	33.3	35.4	36.0	24.5	38.6	31.9
Үйлдвэрлэл	50.9	50.9	27.7	31.6	35.3	22.3	30.9	37.8
Ажил эрхлэлт	49.1	50.9	31.8	43.9	34.8	33.0	32.7	35.1
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	40.2	54.8	61.2	51.1	56.8	62.2	53.3	54.4
Бараа материалын нөөц	55.6	53.1	40.2	44.9	46.8	46.4	42.7	35.9
Дуусаагүй үйлдвэрлэл	58.7	48.8	52.7	51.4	41.8	51.0	51.2	50.0
Бэлэн бүтээгдэхүүн	53.8	50.0	36.3	37.8	43.4	42.3	38.3	39.1
Бүтээгдэхүүний үнэ	73.6	69.1	67.0	63.3	68.8	72.7	75.0	68.9
Худалдан авалтын тоо хэмжээ	49.1	51.0	33.7	33.7	32.7	23.5	33.7	34.0
Түүхий эд, материалын үнэ	88.9	84.3	84.8	81.6	84.6	81.8	94.7	91.5
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	57.4	56.9	40.6	43.8	37.2	35.6	46.3	45.1
Дунд								
Шинэ захиалга	57.1	38.0	55.9	46.2	34.2	45.2	35.4	26.3
Үйлдвэрлэл	71.4	44.0	50.0	50.0	36.8	52.4	39.6	30.4
Ажил эрхлэлт	57.1	42.3	50.0	42.3	30.0	42.9	35.4	37.0
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	53.8	52.0	50.0	33.3	50.0	59.5	50.0	57.1
Бараа материалын нөөц	64.3	58.0	31.6	42.3	52.5	40.5	35.4	30.4
Дуусаагүй үйлдвэрлэл	61.5	56.0	46.9	54.2	45.8	54.8	40.5	52.3
Бэлэн бүтээгдэхүүн	64.3	36.0	42.5	50.0	44.7	45.2	43.8	39.1
Бүтээгдэхүүний үнэ	71.4	71.2	68.4	61.5	68.4	64.3	68.8	67.4
Худалдан авалтын тоо хэмжээ	60.7	31.3	44.7	29.2	27.8	45.2	25.0	32.6
Түүхий эд, материалын үнэ	85.7	90.4	90.0	88.5	89.5	90.5	93.8	100.0
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	46.2	66.0	47.2	62.5	41.7	47.2	35.0	31.8
Том								
Шинэ захиалга	46.3	50.0	39.6	45.4	44.3	53.1	30.4	43.4
Үйлдвэрлэл	53.8	57.4	44.5	49.3	45.2	58.0	29.2	48.3
Ажил эрхлэлт	53.7	58.2	51.8	57.2	52.3	50.0	45.2	50.0
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	36.1	48.2	48.1	44.7	48.8	41.8	58.8	52.7
Бараа материалын нөөц	52.5	62.1	50.9	58.1	44.0	46.8	39.5	44.9
Дуусаагүй үйлдвэрлэл	52.7	52.8	45.8	63.2	51.3	59.1	41.3	51.9
Бэлэн бүтээгдэхүүн	52.5	57.6	54.6	49.2	40.5	62.5	39.2	48.3
Бүтээгдэхүүний үнэ	54.9	69.7	72.3	72.4	61.4	71.3	76.6	76.3
Худалдан авалтын тоо хэмжээ	59.8	56.7	37.7	56.5	45.3	55.1	30.3	45.8
Түүхий эд, материалын үнэ	72.5	85.2	84.8	86.0	78.9	88.0	88.5	91.5
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	59.5	56.9	54.7	52.2	41.9	50.0	38.8	52.6

Барилга

Үзүүлэлт	2024.III	2024.IV	2025.I	2025.II	2025.III	2025.IV	2026.I	2026.II
Барилга	43.3	46.8	41.4	43.2	37.6	35.1	33.6	42.0
Шинэ захиалга	41.7	47.5	37.5	35.6	30.6	32.8	24.0	35.6
Үйлдвэрлэл	47.5	46.0	36.6	43.4	39.6	29.1	31.3	44.5
Ажил эрхлэлт	43.2	43.9	47.3	47.3	38.7	35.3	43.8	43.7
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	46.5	52.8	49.0	50.0	48.8	46.0	45.1	51.7
Бараа материалын нөөц	32.5	43.4	41.5	46.6	34.6	39.9	30.3	37.1
Худалдан авалтын тоо хэмжээ	47.3	46.9	45.7	40.6	46.2	42.0	36.7	46.9
Түүхий эд, материалын үнэ	84.4	91.4	85.4	90.2	84.8	89.9	93.2	91.8
Орон сууцны зах зээлийн идэвхжил	45.6	43.6	49.3	39.4	39.5	37.5	22.7	32.2
Борлуулалтын үйл ажиллагаа	43.5	37.6	40.4	36.6	31.4	30.5	34.2	33.1
Барилга, угсралтын үйл ажиллагаа	47.3	43.2	43.4	38.5	37.5	38.6	42.8	49.5
Туслан гүйцэтгэгч ашиглалт	49.7	48.6	52.1	42.1	45.3	39.2	41.5	43.7
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	45.7	60.3	48.7	42.2	39.5	44.5	39.1	54.8
Жижиг								
Шинэ захиалга	47.9	43.3	33.3	59.1	36.0	35.0	26.3	31.8
Үйлдвэрлэл	60.4	40.6	45.2	50.0	43.5	38.5	33.3	36.4
Ажил эрхлэлт	43.5	25.0	38.6	33.3	33.9	38.5	34.0	29.2
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	47.6	60.0	52.8	44.4	56.8	50.0	60.5	45.5
Бараа материалын нөөц	45.2	34.4	42.5	60.0	25.0	41.7	31.3	36.4
Худалдан авалтын тоо хэмжээ	56.8	50.0	28.9	45.0	28.0	9.1	22.0	45.8
Түүхий эд, материалын үнэ	79.2	90.6	86.4	83.3	76.9	100.0	90.0	100.0
Орон сууцны зах зээлийн идэвхжил	54.3	41.7	44.1	50.0	41.7	25.0	15.8	45.0
Борлуулалтын үйл ажиллагаа	47.8	40.6	26.3	54.5	27.3	21.4	18.8	18.2
Барилга, угсралтын үйл ажиллагаа	56.3	40.0	44.7	50.0	34.2	28.6	30.4	33.3
Туслан гүйцэтгэгч ашиглалт	45.7	30.8	53.1	62.5	28.1	37.5	32.5	37.5
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	43.2	75.0	55.0	87.5	50.0	41.7	32.5	58.3
Дунд								
Шинэ захиалга	31.3	38.5	38.2	36.1	31.8	31.3	50.0	26.5
Үйлдвэрлэл	31.3	34.6	38.9	45.0	35.7	36.4	44.4	31.6
Ажил эрхлэлт	43.8	34.6	41.7	47.5	30.8	40.9	27.8	42.5
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	50.0	50.0	50.0	55.0	63.6	60.0	44.4	55.6
Бараа материалын нөөц	25.0	40.9	44.4	44.7	39.3	31.8	28.6	26.3
Худалдан авалтын тоо хэмжээ	31.3	36.4	44.4	45.0	42.9	27.3	33.3	35.0
Түүхий эд, материалын үнэ	81.3	84.6	80.6	85.0	75.0	77.3	68.8	97.5
Орон сууцны зах зээлийн идэвхжил	43.8	31.3	62.5	25.0	25.0	14.3	42.9	36.8
Борлуулалтын үйл ажиллагаа	31.3	45.5	46.9	31.6	50.0	12.5	43.8	28.9
Барилга, угсралтын үйл ажиллагаа	31.3	36.4	53.1	31.6	40.0	22.2	42.9	44.1
Туслан гүйцэтгэгч ашиглалт	50.0	40.9	33.3	43.3	50.0	21.4	70.0	37.5
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	57.1	59.1	55.9	28.9	23.1	55.6	58.3	20.0
Том								
Шинэ захиалга	42.3	48.9	37.8	33.3	30.0	32.8	20.8	37.0
Үйлдвэрлэл	48.1	47.8	35.5	42.6	39.7	27.4	29.6	46.8
Ажил эрхлэлт	43.1	46.7	48.7	48.6	40.0	34.4	46.6	45.2
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	46.0	52.4	48.5	50.0	46.4	44.0	43.8	51.9
Бараа материалын нөөц	32.1	44.6	41.0	45.6	35.0	40.6	30.4	38.3
Худалдан авалтын тоо хэмжээ	48.1	47.8	47.4	39.7	48.3	46.8	38.5	48.3
Түүхий эд, материалын үнэ	85.2	92.2	85.9	91.4	86.7	90.3	96.3	90.3
Орон сууцны зах зээлийн идэвхжил	45.0	45.1	48.3	40.0	40.9	41.3	21.1	30.4
Борлуулалтын үйл ажиллагаа	44.4	36.4	41.0	35.5	29.6	33.3	34.6	35.0
Барилга, угсралтын үйл ажиллагаа	48.3	44.3	42.1	38.2	37.5	41.4	44.0	51.7
Туслан гүйцэтгэгч ашиглалт	50.0	51.2	54.1	40.0	46.4	41.4	39.1	45.0
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	44.6	59.1	47.3	39.4	40.4	43.5	37.5	58.3

Дотоод худалдаа

Үзүүлэлт	2024.III	2024.IV	2025.I	2025.II	2025.III	2025.IV	2026.I	2026.II
Дотоод худалдаа	52.2	49.2	39.0	43.3	41.3	38.8	36.2	44.3
Шинэ захиалга	53.5	50.8	29.9	36.8	34.8	31.9	29.2	37.4
Үйлдвэрлэл (Борлуулалтын орлого)	56.9	47.2	26.4	43.8	35.8	30.9	28.6	50.7
Ажил эрхлэлт	51.6	49.2	49.6	44.3	50.3	46.1	40.9	46.1
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	40.9	48.9	58.8	50.8	51.1	55.3	45.5	41.6
Бараа материалын нөөц	55.0	49.7	47.4	48.7	41.9	39.6	53.0	49.6
Худалдан авсан барааны дундаж үнэ	82.2	73.3	78.8	78.0	80.0	71.0	85.8	88.1
Худалдан авсан барааны хэмжээ	89.9	75.9	74.7	70.7	81.1	71.3	90.1	89.5
Хүлээгдэж буй борлуулалт	28.6	32.8	9.3	21.7	21.7	18.8	14.7	17.2
Жижиг								
Шинэ захиалга	36.2	34.1	37.5	33.3	24.1	25.0	7.7	29.6
Үйлдвэрлэл (Борлуулалтын орлого)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Ажил эрхлэлт	39.3	35.4	50.0	37.9	28.6	39.3	44.1	34.4
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	53.8	50.0	57.5	61.1	59.3	50.0	50.0	60.7
Бараа материалын нөөц	34.6	36.1	38.2	41.4	28.6	32.1	35.3	23.4
Худалдан авсан барааны дундаж үнэ	78.6	71.7	76.2	69.0	69.6	71.4	76.5	85.9
Худалдан авсан барааны хэмжээ	79.6	61.8	73.7	62.5	73.2	69.2	82.4	89.1
Хүлээгдэж буй борлуулалт	11.1	20.8	20.6	20.7	14.3	25.0	8.3	18.8
Дунд								
Шинэ захиалга	33.3	45.8	27.8	50.0	37.5	22.2	29.2	26.9
Үйлдвэрлэл (Борлуулалтын орлого)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Ажил эрхлэлт	64.3	37.5	44.4	45.0	38.9	40.9	19.2	31.3
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	42.9	50.0	56.3	50.0	33.3	50.0	41.7	40.6
Бараа материалын нөөц	50.0	25.0	44.4	40.0	38.9	63.6	34.6	31.3
Худалдан авсан барааны дундаж үнэ	85.7	62.5	77.8	80.0	83.3	86.4	88.5	87.5
Худалдан авсан барааны хэмжээ	78.6	75.0	62.5	83.3	94.4	77.3	92.3	84.4
Хүлээгдэж буй борлуулалт	25.0	12.5	18.8	35.0	27.8	9.1	15.4	21.9
Том								
Шинэ захиалга	56.7	52.6	29.4	36.0	35.5	33.3	31.0	38.9
Үйлдвэрлэл (Борлуулалтын орлого)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Ажил эрхлэлт	51.6	51.3	50.0	44.8	53.1	47.1	42.4	48.3
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	39.7	48.7	59.1	50.0	51.9	56.3	45.5	40.0
Бараа материалын нөөц	57.1	52.9	48.5	50.0	43.3	38.2	56.1	53.3
Худалдан авсан барааны дундаж үнэ	82.3	74.3	79.2	78.6	80.6	69.7	86.4	88.3
Худалдан авсан барааны хэмжээ	91.7	77.1	75.8	70.4	80.6	71.0	90.6	90.0
Хүлээгдэж буй борлуулалт	30.4	35.5	7.6	20.7	21.9	19.1	15.2	16.7

Үйлчилгээ

Үзүүлэлт	2024.III	2024.IV	2025.I	2025.II	2025.III	2025.IV	2026.I	2026.II
Үйлчилгээ	53.3	52.6	45.8	40.3	46.8	44.5	42.2	41.9
Шинэ захиалга	51.6	51.6	43.4	39.6	38.9	43.2	38.5	38.6
Үйлдвэрлэл (Бизнесийн идэвхжил)	60.6	60.3	41.7	36.0	50.1	42.4	40.2	42.2
Ажил эрхлэлт	50.8	50.6	47.7	39.5	49.8	46.3	47.5	43.3
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	48.1	45.0	54.4	49.7	52.4	47.9	45.7	45.9
Түүхий эд, материалын үнэ	73.8	81.4	84.9	85.5	78.5	82.8	92.7	92.0
Үйлчилгээний үнэ	69.0	72.1	71.2	68.3	68.2	66.2	72.2	70.0
Дуусаагүй ажил үйлчилгээ	62.1	52.1	54.6	52.5	63.6	64.3	60.5	55.0
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	54.2	61.4	58.2	44.4	42.1	41.3	50.9	42.9
Жижиг								
Шинэ захиалга	35.9	32.2	31.5	38.3	27.1	29.8	42.4	23.7
Үйлдвэрлэл (Бизнесийн идэвхжил)	41.1	37.2	28.3	35.6	26.9	30.0	30.0	21.7
Ажил эрхлэлт	41.3	43.6	35.5	45.3	40.6	41.8	32.1	37.0
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	48.8	50.0	61.5	59.3	57.1	52.4	54.1	60.6
Түүхий эд, материалын үнэ	75.6	80.8	90.7	80.9	81.6	83.7	87.7	80.5
Үйлчилгээний үнэ	68.9	63.6	70.0	67.0	69.2	63.0	70.4	65.1
Дуусаагүй ажил үйлчилгээ	56.0	54.2	56.3	51.3	58.3	59.8	48.8	57.1
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	52.3	54.5	42.6	41.3	36.0	53.1	32.4	46.6
Дунд								
Шинэ захиалга	57.7	41.2	38.6	43.5	22.2	38.5	17.9	37.5
Үйлдвэрлэл (Бизнесийн идэвхжил)	54.2	50.0	39.1	45.5	27.5	34.5	31.6	32.5
Ажил эрхлэлт	38.5	39.5	43.5	45.7	40.5	34.5	40.0	45.0
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	57.7	38.5	53.1	50.0	46.4	44.0	44.1	50.0
Түүхий эд, материалын үнэ	83.3	87.5	72.5	85.7	88.9	87.5	84.2	77.8
Үйлчилгээний үнэ	69.2	80.6	77.5	63.6	73.8	63.0	62.5	65.8
Дуусаагүй ажил үйлчилгээ	63.6	64.3	61.1	59.4	60.0	56.5	53.8	58.8
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	50.0	38.9	52.3	43.2	33.3	42.0	47.4	30.0
Том								
Шинэ захиалга	52.4	53.8	44.7	39.4	40.9	44.5	39.6	39.8
Үйлдвэрлэл (Бизнесийн идэвхжил)	62.5	62.7	42.9	35.5	53.3	43.9	41.5	44.4
Ажил эрхлэлт	52.3	51.8	49.0	38.6	51.1	47.4	49.2	43.7
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	47.4	45.0	53.9	48.9	52.4	47.8	45.1	44.4
Түүхий эд, материалын үнэ	73.1	81.0	85.2	85.9	77.6	82.4	93.6	93.9
Үйлчилгээний үнэ	69.0	72.2	70.8	68.8	67.8	66.7	73.0	70.6
Дуусаагүй ажил үйлчилгээ	62.5	51.1	54.1	52.1	64.3	65.2	61.8	54.5
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	54.7	63.5	59.8	44.7	43.2	40.4	52.6	43.4